



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 он 10 сарын 06 өдөр

Дугаар 1/114

Дэлгэрхаан сум

Ахмадын урлагийн 5 дугаар наадамд
дэмжлэг үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сумын Засаг даргын үйл ажиллгааны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 3.1 заалт болох төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдах "Ахмадын урлагийн 5 дугаар наадам", "Хөдөлмөрч манлай ахмадын 2 дугаар чуулган"-д дэмжлэг үзүүлэх зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Үйл ажиллагаанд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2325010251

Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06
-ны өдрийн 11 дугаар захирамжийн хавсралт



АХМАДЫН УРЛАГИЙН 5 ДУГААР НААДАМ, ХӨДӨЛМӨРЧ МАНЛАЙ
АХМАДЫН ЧУУЛГАНЫ ЗАРДАЛ

д/д	Машины тоо	Нэг машинд орох бензин	Нийт бензин	1л бензин	Нийт үнэ1
1	3	30	90	2740	250,000
Байрлах байрны зардал					
	Өрөөний тоо	хоног	Өрөөний үнэ	Нийт өртөг	
1	2	2	100,000	400,000	
Хоолны зардал					
	Нийт хүний тоо	Нэг хүн	Нийт	Хоёр өдөрт	
1	10	20,000	200,000	400,000	

